

## Даатгалын талаарх таны мэдлэгт: Мэдээлэл, зөвлөмж

Ниймийн даатгал болон эрүүл мэндийн даатгалыг хүн бүр сайн мэддэг. Харин бидний өдөр тутмын амьдралд үргэлж тохиолдоод байдаггүй учир бусад санамсаргүй эрсдлүүдийн даатгалын талаар мэдээлэл бага байдаг. Аливаа гэнэтийн тохиолдол ээрэг, сөрөг талтай. Сөрөг талынх нь гэвэл элдэв өвчин, гэнэтийн аюул, үйлдвэрлэлийн болон ахуйн осол, мөн газар хөдлөлт, цасан болон шороон шуурга, хүчтэй салхи, аадар бороо, мөндөр, аянга, үер, хөрсний нуралт, цөмрөлт гэх мэт эрсдлүүд байна.

Сүүлийн үед байгаль, цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалсан гамшигт үзэгдэл ихсч байгаагаас иргэд, аж ахуйн нэгж байгууллага эд хөрөнгийн хохирол үүрч, үүссэн эрсдлийг даван туулахад тодорхой хэмжээний санхүүгийн дарамтанд өртөж, бие хүн сэтгэл санааны болон бие махбодийн хохирол амсч байна. Иймээс аливаа хувь хүн, албан байгууллагын хэвийн байдлыг алдагдуулсан гэнэтийн болон санамсаргүй, эрсдэл дагуулсан үйл явцаас үүсэх хохирлыг бууруулах, нөхөх санхүүгийн үр дүнтэй арга хэрэгсэл нь даатгал юм.

Даатгал нь даатгалын гэрээний үндсэн дээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд эрсдэлээ даатгуулж, даатгалын хураамж төлөх, гэрээний хүчинтэй хугацаанд даатгалын тохиолдол болсон үед даатгалын компаниас нөхөн төлбөр олгох итгэлцэл дээр суурилдаг үйл ажиллагаа юм. Даатгал сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй. Ихэнх даатгал тухайлбал, хөдөлмөрийн чадвар тур алдалтын, гэнэтийн ослын, эд хөрөнгийн, тээврийн хэрэгслийн даатгал нь иргэд, хуулийн этгээдийн сайн дурын үндсэн дээр хийгддэг бөгөөд харин албан журмын даатгал нь тухайлсан хуулинд тусгагдан, эрсдэл, нөхцлийн талаар нарийвчилан оруулсан тусгай журмаар зохицуулагддаг. Жишээлбэл, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалыг нэрлэж болох бөгөөд тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигч, зам тээврийн хөдөлгөөнд оролцогч жолооч бүр өөрийн хариуцлагаа заавал даатгуулах үүрэгтэй.

Харин тээврийн хэрэгслийн даатгал нь гал түймэр, аянга цахилгаан, газар хөдлөлт, хүчтэй салхи шуурга, мөндөр, үер зэрэг байгаль, цаг уурын үзэгдлийн улмаас учирч болзошгүй эрсдэл, цахилгаан болон сантехникийн шугамын гэмтэл болон байшин, барилга байгууламжийн нуралт, мөн гадны нөлөөлөл, хөндлөнгийн этгээдийн санаатай болон санамсаргүй үйлдлийн улмаас бий болж болзошгүй эрсдлээс иргэн, хуулийн этгээдийн тээврийн хэрэгслийг даатгах, учирсан хохирлын нөхөн төлбөрийг даатгалын гэрээнд заасан нөхцлийн дагуу барагдуулах зорилго бүхий сайн дурын даатгал юм. Мөн сайн дурын даатгалын төрөл болох эд хөрөнгийн даатгалд орон сууц, зуслангийн байшин, гэр, хашаа, тавилга, эд хогшил, цахилгаан, электрон тоног төхөөрөмж, бараа материал, мал, амьтад хамрагддаг.

Энд даатгуулагчийн мэдвэл зохих нэгэн чухал зүйл бол ямар ямар эрсдэлээ, хэдий хэмжээгээр үнэлэн даатгуулах гэж байгаа болон хэдэн төгрөгийн хураамж төлөх зэргээ зөв сонгох хэрэгтэй. Даатгалын тохиолдол гэж тооцох нөхцлүүд, нөхөн төлбөрийн хэмжээ зэргийг заасан даатгалын гэрээний нөхцөлтэйгээ сайтар танилцах шаардлагатай юм. Ямар эрсдэлүүдийг хамруулан даатгаж буйгаас хураамжийн хэмжээ хамаардгийн зэрэгцээ хэрэв эд хөрөнгө даатгуулж буй бол түүний ашиглалтын нөхцөл байдал нь эрсдэл үүсч болзошгүй стандарт бус тоног төхөөрөмж хэрэглэдэг эсэх,

технологийн бус үйл ажиллагаа явуулдаг эсэх гэх мэт нөхцөл байдлыг даатгалдын байгууллагаас урьдчилан судлаад зарим шаардлагуудыг хангасан байх нөхцлийг тавьж болдог гэдгийг анхаарах хэрэгтэй.

Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын даатгуулах идэвхи төдийлөн сайн бус байгаа нь нэг талаас даатгалын агуулга, ач холбогдлын талаарх мэдлэг, ойлголт хангалтгүй, нөгөө талаас тэдний даатгуулах идэвх, хүсэл сонирхол сул, үл ойшоосон хандлагаас ихээхэн хамаарч байна.

“Өнгөрсөн саруудад болсон үерийн улмаас 21 аймгийн хэмжээнд айлын 520 гэр, 269 байшин, 197 барилга байгууламж, 66 автомашин өртөж, 4,000 гаруй толгой мал хорогдсон тухай” Улсын Онцгой Комиссоос үерийн гамшгийн талаар хийсэн мэдээлэлд онцолжон байна. /эх сурвалж: ikon.mn 2023.08.15/

Аадар бороо, аянга, мөндөр, хүчтэй салхи, шуурга, зуд турхан тохиолдох, гэнэтийн аюул, осол байгалийн давагдашгүй хүчин зүйлийн эрдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүх шатанд сайжруулах, бэлэн байдал, бэлтгэл ажлыг сайтар хангахаас гадна даатгалын хамгаалалт, үйлчилгээг авч, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хариуцлагаа даатгуулж, даатгалын тохиолдол болсон үед даатгалаар дамжуулан учирсан хохиролоо нөхөх, санхүүгийн эрсдэлээ бууруулах боломжийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага ашиглах амьдралын шаардлага бий болж буй өнөө үед манай даатгалын зах зээлд үйл ажиллагаа эрхэлж буй Сангхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөлтэй даатгалын 18 компанийн үүд хаалга нээлттэй байгааг уламжилж, олон нийтийг даатгалд идэвхтэй хамрагдахыг зөвлөж байна.

“Ган зам даатгал” компанийн хувьд даатгалын тохиолдлыг бүртгэх, материалыг хүлээн авч судлах, хохирлын үнэлгээг шалган тооцож нөхөн төлбөрийг олгох ажлыг компанийн зүгээс шалтгаалах хүндэрэл чирэгдэлгүй, түргэн шуурхай шийдвэрлэх, даатгуулагчдынхаа итгэлийг бэхжүүлэн ажиллахад онцгой анхаарч, тэдний өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллаж байна. Тус компани зөвхөн байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалсан эрсдэлд олгосон нөхөн төлбрийг жишээ болгоход: энэ оны 4, 5-р сард Дорноговь, Говьсүмбэр аймгийн нийт нутгаар олон удаагийн давтамжтай шороон шуурга шуурч, гамшигт үзэгдэл болж, галт тэрэгний хөдөлгөөний аюулгүй байдалд саад учруулсан үеэр ажилласан Замын 3-р ангийн шуурхай үйлчилгээний болон хэсгийн 9, Дохиолол холбооны 3-р ангийн 4, Замын 4-р ангийн 7 нийт 20 тээврийн хэрэгслийн цонх, салхины шил, гэрэл дохио, нүүр буфер, крыло гэмтснийг Цаг уур, орчны шинжилгээний газрын ажиглалтын мэдээ, тодорхойлолт авч, баталгаажуулан 13.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулж, техникийн бүрэн бүтэн байдлыг хангуулсан болно.

Даатгалд хамрагдсан иргэд, байгууллага сүүлийн үед болсон хүчтэй аадар борооны улмаас учирсан хохирлоо хэрхэн барагдуулах, цаашид учирч болзошгүй эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар дараах зөвлөмжийг өгч байна.

- Даатгуулсан тээврийн хэрэгсэл, эд хөрөнгөд үерийн улмаас хохирол учирсан бол даатгалын гэрээний “эрсдэл” хэсэгт “Үер, усны эрсдэл” болон “Байгалийн гамшигт үзэгдлийн эрсдэл”-ийг сонгож даатгуулсан эсэхээ шалгах;

- Хэрэв даатгалын гэрээгээ үрэгдүүлсэн бол Монголын даатгалын холбооны 77668001 дугаарын утсанд болон тус холбооны фейсбүүр хуудсанд хандаж, тээврийн хэрэгслийн улсын дугаараар нь даатгалтай эсэхээ шалгуулж, зөвлөгөө, мэдээлэл авах;

- Үерт хохирсон тээврийн хэрэгсэл, эд хөрөнгө нь банк болон банк бус санхүүгийн байгууллагын зээлийн барьцаанд байгаа бөгөөд даатгалтай эсэхээ мэдэхгүй бол тухайн банк болон банк бус санхүүгийн байгууллагад хандаж, даатгалын гэрээ байгуулсан эсэхийг шалгуулж, даатгуулсан бол тухайн даатгалын компанийд хандах;
- Цаг уур, орчны шинжилгээний газрын байгалийн аюулт үзэгдэл, хүчтэй салхи шуурга, үер ус, цас, зудны талаарх албан ёсны мэдээг тогтмол авч, энэ үндсэн дээр иргэд, байгууллага өөрсдийн амь нас, эд хөрөнгөө хамгаалах, учирч болзошгүй эрсдэлийг бууруулах арга хэмжээг авч байхыг хэвшил болгох нь зүйтэй байна.

“Ган зам даатгал” ХХК